

<http://gijc2015.org/2015/10/19/fact-check-your-story-before-its-too-late/>

Оройтоогүй дээр баримтаа нягтлан шалга

Abby Ellis

Эрх мэдэлтнүүдтэй хариуцлага тооцох хэмжээнд иргэдийг чадавхжуулах тийм хүчирхэг сэтгүүлзүйн бүтээлийг амжилттай нийтэлж, нэвтрүүлэхийн тулд юун түрүүнд бүтээл тань итгэл үнэмшилтэй байх ёстой.

“Баримтыг нягтлан шалгах нь ажил мэргэжлийн амжилтад хүрэх даатгал юм” хэмээн Шведийн олон нийтийн телевизийн туршлагатай эрэн сурвалжлах сэтгүлч Нилс Хансон Эрэн сурвалжлах сэтгүүлзүйн олон улсын хурлын үеэр болж өнгөрсөн “Оройтоогүй дээр баримтаа нягтлан шалга” сэдэвт уулзалтыг нээх үеэрээ хэлсэн юм.

“Алдаа бүрийг бидний эсрэг ашиглах болно”

Хансон Шведийн олон нийтийн телевизэд хэрэгждэг журмыг жишээ татаж, бүтээлийг нийтэлж нэвтрүүлэхээс өмнө чанарын шалгалт хэрхэн хийх талаар дараах санал, зөвлөмжийг өгсөн юм.

АНХААР

Харахыг хүссэн нэг л зүйлдээ анхаарлыг хандуулж, санаа бодлыг тань дэмжих баримт мэдээлэлд илүү ач холбогдол өгөхөөс болгоомжил. Та бодит баримтыг дэлгэж байлаа ч, бүтэн үнэнийг дэлгэж байна уу? гэдгээ эргэцүүлэн бод.

ӨӨРӨӨСӨӨ АСУУ

Би ямар түүхийг өгүүлэх гэж буй билээ? Эсрэг талыг сонсохоос өмнө асуудал бүрэн гүйцэд тодорхой болохгүй.

Би байгаа дүр зургийг шударга үнэнээр харуулах гэж байна уу? Сөрөг талд нь илүү төвлөрөөд байна уу? Би хоёр талаас хоёулангаас нь шүүмжлэлт асуулт тавьж чадаж байна уу?

Ямар нэг зүйл авцалдахгүй байна уу? Ерөнхий өнгө, бичлэгийн уур амьсгал маань зохистой байна уу?

Ямар нэг байдлаар би алдаа гаргаж байж болох уу? Өөртөө хамгийн шүүмжлэлтэй хандагч чөтгөр бай.

<http://gijc2015.org/2015/10/19/fact-check-your-story-before-its-too-late/>

Эрэн сурвалжлагдаж буй этгээдтэй холбоотой, асуудлыг зөөлрүүлэхүйц ямар нэгэн нөхцөл байдал ажиглагдаж байна уу?

Бүх баримт зөв гэдгийг нягтлан шалгасан уу? Нэр, албан тушаал, тоо, ишлэл, график болон бусад мэдээлэл үүнд хамаарна.

Ач холбогдолтой өөр бусад мэдээллийг орхигдуулж байгаа юм биш биз? Өөр баримт орж ирэхэд ерөнхий дүр зураг өөрчлөгдөх үү? Тэдгээрийг бичвэрт оруулахгүй байх шалтгаан нь юу вэ?

Бүх дүгнэлт тань үндэслэл сайтай байж чадаж байна уу? Дүгнэлтээ илүү хурц болгох, эсвэл зөөлрүүлэх шаардлага байна уу?

Бүтээл нийтлэгдсэний дараа ямар шүүмжлэл гарч болзошгүй вэ? Бүх зүйлийг өөртөө нягт нямбай тэмдэглэж үлдээсэн үү?

ЗӨВЛӨМЖ

Бүх төрлийн эсэргүүцлийг талархан хүлээж ав. Хүн бүртэй ярилц, мэргэжилтнүүдийн яриаг шалга, хохирогчдод эргэлзээтэй ханд.

Бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд бүү найд.

Тодорхой бай. Хэрэв 280 гэдэг нь тодорхой байвал “хэдэн зуу” гэж бүү ерөнхийл.

Хүн бүрийн ашигладаг ерөнхийллөөс зайлсхий. “Тэд юу ч хийсэнгүй...” “Босогчид улс орон даяар тархаж байна...” гэх мэт. Үнэхээр тэгж байгаа гэж үү?

Зорилтот субъект буюу “хэргийн эзэн”-тэй боломжийнхоо хэрээр эрт нүүр тул. Хэрэв тэр хариу өгөхгүй бол уулзаж, санал бодлыг нь сонсох гэсэн бүх оролдлогоо баримтжуулан тэмдэглэж ав.

Бэлэн болсон нийтлэл/нэвтрүүлгээ ахин нэг уншиж / үзэж ерөнхий дүр зураг ямархуу байгааг хяна. Бүтээл тань итгэл үнэмшилтэй, тэнцвэртэй болж чадсан уу?